

Б-СӨБ-3 маягтын үзүүлэлтийг системээс гаргах зааварчилгаа

Б-СӨБ-3 маягтын үзүүлэлтийг системээс гаргах зааварчилгаа

Маягтын үзүүлэлтийг дараах дүрмээр бодно.

Анхаарах нь:

- ✓ **Бүх ажилчдыг тоолохдоо** Хүний нөөцийн системд ажил эрхлэлт нь Батлагдсан, төлөв нь Идэвхтэй, давхар ажил эрхлэлттэй бол Үндсэн ажил эрхлэлтийг нь тоолно.
 - ✓ **Гэрээгээр ажиллаж байгаа ажилчдыг тоолохдоо** Хүний нөөцийн системд бүртгэхдээ ажилтны төрөл нь гэрээт ажилтан сонгогдсон, ажил эрхлэлт нь Батлагдсан, төлөв нь Идэвхтэй, давхар ажил эрхлэлттэй бол Үндсэн ажил эрхлэлтийг нь тоолно.
 - ✓ **Тэтгэвэрээ тогтоолгоод ажиллаж байгаа үзүүлэлтийг тоолохдоо** Хүний нөөцийн системд ажил эрхлэлт нь Батлагдсан, төлөв нь Идэвхтэй, давхар ажил эрхлэлттэй бол Үндсэн ажил эрхлэлтийг хувийн мэдээллийн үндсэн мэдээлэл хэсэг дэх тэтгэвэр тогтоолгосон эсэх талбар чеклэгдсэн ажилтныг тоолно.
- Б-СӨБ-3 маягт дахь мөрийн үзүүлэлтийг бодохдоо дээр тайлбарласан багана бүрийн харгалзах дүрэм болон доорхи дүрмээр бодно.
1. **Үзүүлэлт** багана дахь албан тушаалыг гарын авлагын СӨБ маягтын зөвлөмж хэсгийн Ажлын ангилалыг хэрхэн зөв сонгох вэ? хэсэгт үзүүлснээр тоолно.
- Жич: Эрхлэгчийг 1120-26, 1121-20, 1341-11 ажлын кодтой ажлын байр үүсгэж тухайн ажлын байранд дээрхи багана дахь харгалзах дүрмээр бодогдоно.
2. Зөв кодтой ажлын ангилал үүсгэсэн ажлын байранд ажилтны ажил эрхлэлтийг баталгаажуулсан байх гэх мэт дээрх дүрмээс гадна нэмж дүрэм шалгадаг үзүүлэлтийг доор тайлбарлалаа.
- 2.1. Бүлгийн** (үндсэн багш) мөрөнд
- Хүний нөөцийн системд 2342-11, 2342-12, 2342-13 кодтой ажлын байранд батлагдсан Боловсролын удирдлагын системийн хариуцсан анги, бүлгийн хариуцсан үүрэг талбарт "Анги удирдсан багш" (бүлгийн болон хувилбартын бүлэгт анги удирдсан багш сонгогдсон бол бүлгийн мөрөнд тоолно) сонголтыг сонгосон, тухайн бүлгийн хөтөлбөр нь "СӨБ-Сүргүүлийн өмнөх боловсролын хөтөлбөр (ердийн)", бүлгийн ангилал нь "Үндсэн бүлэг" гэж сонгогдсон хүнийг тоолно.
- Нэг бүлэгт бүлэг удирдана. Олон бүлэгт бүлэг удирдсан багшаар сонгогдсон бол үндсэн **бүлгийг** л тоолно.

2.2. Ээлжийн бүлгийн мөрөнд

Хүний нөөцийн системд '2342-11, 2342-12, 2342-13' кодтой ажлын ангилалд хамаарах, хариуцсан анги, бүлгийн хариуцсан үүрэг талбарт зөвхөн нэг бүлэгт "Анги удирдсан багш" сонголтыг сонгосон, тухайн бүлгийн хөтөлбөр нь "СӨБ- Сүргүүлийн өмнөх боловсролын хөтөлбөр (хувилбарт)" , бүлгийн ангилал нь "Ээлжийн бүлэг" гэж сонгогдсон хүнийг тоолно.

2.3. Нүүдлийн бүлгийн мөрөнд

Хүний нөөцийн системд '2342-11, 2342-12, 2342-13' кодтой ажлын ангилалд хамаарах, хариуцсан анги, бүлгийн хариуцсан үүрэг талбарт зөвхөн нэг бүлэгт "Анги удирдсан багш" сонголтыг сонгосон, тухайн бүлгийн хөтөлбөр нь "СӨБ- Сүргүүлийн өмнөх боловсролын хөтөлбөр (хувилбарт)" , бүлгийн ангилал нь "Нүүдлийн бүлэг" гэж сонгогдсон хүнийг тоолно.

2.4. Явуулын багш мөрөнд

Хүний нөөцийн системд '2342-11, 2342-12, 2342-13' кодтой ажлын ангилалд хамаарах, хариуцсан анги, бүлгийн хариуцсан үүрэг талбарт зөвхөн нэг бүлэгт "Явуулын багш" сонголтыг сонгосон, тухайн бүлгийн хөтөлбөр нь "СӨБ- Сүргүүлийн өмнөх боловсролын хөтөлбөр (хувилбарт)" , бүлгийн ангилал нь "Явуулын бүлэг" гэж сонгогдсон хүнийг тоолно.

2.5. Туслах багш мөрөнд

Хүний нөөцийн системд 2342-14, 5312-11, 5312-12 кодтой ажлын байранд ажил эрхлэлт нь батлагдсан Боловсролын удирдлагын системийн хариуцсан анги, бүлгийн хариуцсан үүрэг талбарт "Туслах багш" гэж сонгогдсон хүнийг тоолно.

2.6. Ээлжийн багш мөрөнд

Хүний нөөцийн системд '2352-11, 2352-13, 2352-14, 2352-15, 2352-16, 2352-17, 2342-17-аас 2342-34, 2352-20, 2342-14, 5312-11, 5312-12, 2264-12, 2264-14, '2342-11, 2342-12, 2342-13' кодтой ажлын байранд батлагдсан Боловсролын удирдлагын системийн хариуцсан анги, бүлгийн хариуцсан үүрэг талбарт "Ээлжийн багш" гэж сонгогдсон хүнийг тоолно.